



---

## Онош - Diagnos - Diagnosis - Диагноз

---

**Монголын анагаах ухааны мэргэжлийн нийгэмлэгүүдийн  
Эрдэм шинжилгээ-практикийн улирал тутмын сэтгүүл**

**2009 он**

**Сэтгүүлийн цэц**

С.Бадамжав /Эрхлэгч/  
Б.Дагвадорж, А.К.Жангабылов, Н.Бира,  
Р.Бямбаа, Б.Ганбаатар, Г.Зулхүү,  
Г.Сүхбат, Ц.Сарантуяа

**Сэтгүүлийн зөвлөл**

Д.Гончигсүрэн, Д.Цэрэндагва, Н.Баярмаа,  
Д.Даваадорж, Х.Оюунцэцэг,  
Б.Гомбосүрэн, Д.Энэбиш, С.Гантуяа

**Дугаар № 4 (44)**


**Арван нэг дэх жилдээ**

**Улиралд нэг удаа**

(Захиалгын үнэ 4000 төг, худалдаалах үнэ 5000 төг)

Хууль зүйн яамны бүртгэл №175  
Сэтгүүлийн эхийг бэлтгэсэн  
М.Мөнхтүшиг  
Индекс 14175

Сэтгүүлийн зөвлөл:  
Улаанбаатар 210648  
Холбооны газар 49  
Шуудангийн хайрцаг  
“Онош” сэтгүүл  
E-mail: s.badamjav@yahoo.com  
Утас: 99110120



**Монголын гастроэнтеролог эмч нарын нийгэмлэгийн улирал  
тутмын сэтгүүл №4 (44) 2009**

---

Сэтгүүлийн 10 жилийн ойд зориулсан мэндчилгээ 4

**СУДАЛГАА**

|                                                                                                                                                                      |    |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Батболд.Д , Ганбаатар.Б, Чимэдсүрэн.О III шатлалын эмнэлгийн<br>(УКТЭ, ШТЭ, ТТАХНЭ,ЭНЭШТ) эмч, сувилагчдын дунд гепатитын<br>В (HBV), С (HCV) вирусын халдвар илрэлт | 12 |
| А.Аварзэд, Б.Ганбаатар Стафилококкийн илрэлт, антибиотик<br>мэдрэг чанарыг тодорхойлсон нь                                                                           | 15 |
| Т.Хонгорзул , С.Цогтсайхан, С.Бүжинлхам, Ж.Батаа Б.Батцэцэг, Ж.Эрдэнэбаатар<br>Хүний бруцеллөз өвчний серологийн оношлогооны харьцуулсан үзүүлэлтүүд                 | 19 |
| Ц.Цэрэндолгор, Б.Хандсүрэн, О.Чимэдсүрэн , Б. Гэрэлханд<br>«Ирээдүйн босго»өсвөр үеийн эрүүл мэндийн төвийн бүтэц зохион<br>байгуулалтанд хийсэн үнэлгээ             | 21 |
| Ц.Сарантуяа, Н.Бира, Б.Сувд, Б.Болор, А.Булганчимэг Лейкеми өвчтэй<br>хүүхдүүдийн хоол тэжээлийн асуудалд                                                            | 25 |

**ЛЕКЦ**

|                                                                                                                                          |    |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| S. Badamjav MD, PhD, B. Oyuntsetseg MD, PhD, HSUM, College of Medicine<br>Modern clinical use and significance of Mare's milk            | 28 |
| Б.Ганбаатар, С.Бадамжав, А.Аварзэд Нобелийн шагнал хүртсэн анагаахын салбарын<br>эрдэмтдийн тухай                                        | 30 |
| Н.Баярмаа Современные принципы диагностики и лечения острого панкреатита                                                                 | 45 |
| Б. Оюунцэцэг ЦӨСНИЙ ЧУЛУУ ҮҮСЭЛТИЙН ЭМГЭГ ЖАМЫН ОРЧИН ҮЕИЙН ОЙЛГОЛТ                                                                      | 50 |
| Ц.Жаргалсайхан, Г.Эрдэнэчимэг, Б.Гэгээбадрах, Ю.Пүрэвсүрэн, Б.Мягмаржав<br>Эрүүл мэндийн даатгалыг<br>боловсронгуй болгох зарим арга зам | 63 |

**ДУРСАМЖ**

|                                            |    |
|--------------------------------------------|----|
| Б.Дагданбазар ЗҮРХНИЙ ДОКТОР ЦАМБЫН БУНДАН | 76 |
|--------------------------------------------|----|

**ХАВСРАЛТ**

|                                                                                                                                                                           |    |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Монголын анагаах ухааны мэргэжлийн нийгэмлэгийн эрдэм шинжилгээ, практикийн улирал<br>тутмын “Онош” сэтгүүлд 1999 - 2009 онд хэвлэгдсэн эрдэм судлал, лекцүүдийн жагсаалт | 78 |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|



Монголын Анагаахын онош зүйн шинжлэх ухааныг үндэслэгч,  
Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Халх голын дайчин,  
Монгол Улсын Хүний гавъяат эмч, Академич, Анагаахын шинжлэх  
ухааны доктор, профессор Бямбажавын РАГЧАА  
/1915-1996/



## Сэтгүүлийн 10 жилийн ойд зориулсан мэндчилгээ

Хэвлэл мэдээллийн хууль 1990 оны сүүлчээр гарч, өдөр тутмын цөөн сонин, улирал тутмын сэтгүүлүүд гарч байсан нь арай өөрчлөгдөж, анагаах ухааны салбар, нийгэмлэгүүд улирал тутмын сэтгүүл гаргаж эхэллээ. Удалгүй энэ төрлийн сонин сэтгүүлийн тоо ч жилээс жилд өсөх хандлагатай боллоо. Тэр үед гастроэнтерлогийн мэргэжил эзэмших дамжаанд сурч байсан 20 гаруй эмч, АУИС-ийн Гастроэнтерлогийн тэнхимийн багш бид харилцан ярилцаж дэлхийн хандлагыг дагах нь зүйтэй гэж үзсэний эцэст мэргэжлийн нийгэмлэгээ байгууллаа. Доктор Д.Гончигсүрэн “Дүрс оношлогоо” сэтгүүл гаргажээ. Энэ сэтгүүл нь бичгийн цаас хуваасантай тэнцэх авсаархан хэмжээтэй аж. Үүнээс гадна хэд хэдэн багш нар бас өөрсдийн мэргэжлийн сэтгүүлүүдийг санаачлан эхний дугаарууд нь хэвлэгдэж эхлэв. Миний бие тэр үед сэтгүүл гаргах санал тавьж гавьяат эмч Б.Дагвадорж багшид болон бусад багш нартаан

хэлж тэд нарч надад урам өгсөн билээ.

Хэвлэлийн эрх чөлөөний хууль дүрмийн дагуу бичиг баримтаа бүрдүүлж Хууль зүйн яаманд хүргүүлэн хэсэг хугацааны дараа “Онош” сэтгүүлийн эрхийн гэрчилгээг 1999 он 4 сарын 12-нд өгснөөс хойш эдүгээ 11 дэх жилдээ 44 дугаарыг уншигчдын гар дээр хүргэжээ.

Тогтмол хэвлэлийн захиалганд 2000 оноос оруулж одоо улс орон даяар захиалагддаг, анагаахын оюутан, багш, эмч, судлаачдын мэдлэгт дэм болох сэтгүүл болсон юмуу даа гэж боддог. А.К.Жангабылов, Б.Дагвадорж, Б.Ганбаатар, Р.Бямбаа, Г.Сүхбат, Н.Бира, Ц.Сарантуяа нар сэтгүүлийн цэцийн гишүүнээр, Д.Гончигсүрэн, Д.Цэрэндагва, Н.Баярмаа, Д.Дагвадорж, Х.Оюунцэцэг, Б.Гомбосүрэн, Д.Энэбиш, С.Гантуяа нар сэтгүүлийн зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. Сэтгүүлийг бэлтгэн гаргаж эхэлснээс хойшхи 10 жилийн хугацаанд сэтгүүлийн агуулга, хэвлэлийн чанар чансааг сайжруулахад байнга анхаарч ирлээ бид.

Сэтгүүлийн 5 жилийн ойг 2004 онд тэмдэглэсэн юм. Энэ онд сэтгүүлийн 10 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд “Зөвлөх эмч нарын шилдэг лекцүүд” уншигдахаар төлөвлөгдсөн ч А хүрээний H1N1 вирусн тархалтын улмаас энэ арга хэмжээ тасарсанд хүлцэл өчье. Эмч, сэтгүүлч Р.Бямбаагийн саналаар сэтгүүлийн эхний нүүрэнд Монголд онош зүйн шинжлэх ухааныг үндэслэгч академич, хүний гавьяат эмч, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор Бямбажавын Рагчаагийн хөргийг байнга тавьсан нь ахмад үеийнхний нэр хүндийг өргөх боломжтой ажил болсон санагдана.

С.Сарангэрэл, Ц.Сарантуяа, Б.Гомбосүрэн Д.Энэбиш нар сэтгүүлийн онуудын шагналуудыг авчээ. Цаашид “Онош” сэтгүүлийн чанарыг дэлхийн жишигт хүргэх зорилт тавин “Анагаах ухааны Азийн сэтгүүлүүдийн холбоо”-нд элсэхээр бэлтгэж байгааг дурдъя. “Онош” сэтгүүлийн 10 жилийн ойн мэндчилгээг бүх захиалагч, оюутнууд, эмч, багш, судлаачдад хүргэж ажлын амжилт хүсье.

НОМЫН ЦАГААН БУЯН ОРШИХ БОЛТУГАЙ.

СЭТГҮҮЛИЙН ЭРХЛЭГЧ

С.БАДАМЖАВ



№ .175 .

С.БАДАМЖАВ

ийн  
ӨРГӨДӨЛ, ХОЛБОГДОХ МАТЕРИАЛЫГ ХЯНАН  
ХЭЛЭЛЦЭЭД “ОНОШ”

СЭТГҮҮЛ -Г  
УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭЖ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОВ.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ

19 .99 . оны IV . сарын .12.

## Сэтгүүлийн цэцийн гишүүд



**Бямбын Дагвадорж Хүний гавьяат эмч, АУ-ы доктор, профессор**

- «Элэг» хувийн эмнэлгийн захирал
- Дотрын ерөнхий эмчийн мэргэжилтэй
- Хоол боловсруулах эрхтэн судлал, элэгний эмгэг судлалын чиглэлээр нарийн мэргэжил эзэмшсэн, энэ мэргэжлээрээ 40 гаруй жил ажиллаж байгаа
- Дотрын онош зүй, дотрын өвчин судлалын багш, тэнхимийн эрхлэгчээр АУИС-д 28 жил ажилласан
- Дотор өвчин, хоол боловсруулах эрхтэн судлалын олон зуун эмчийн мэргэжлийг дээшлүүлж, 12 эмч, багшийн эрдэм судлалын ажлыг удирдан, эрдмийн болон магистрын зэрэг хамгаалуулсан.
- Элэг судлалын чиглэлээр улсын хэмжээнд зөвөлгөө өгөн ажилладаг.
- БНСЮУлсын (хуучнаар) Бельград, Москва, Софи, Японы Нагоя, Бангкок, Дели, Бээжин, Сөүл

хотуудын их дээд сургууль, эмнэлгүүдэд суралцан, мэргэжил дээшлүүлсэн

- Дэлхийн Гастроэнтерологийн холбооны гишүүн, Азийн орнуудын элэг судлалын холбооны тэргүүлэгч
- Монголын Гастроэнтеролог эмч нарын холбооны ерөнхийлөгч
- Вирусын шалтгаант элэгний идэвхит архаг үрэвслийн эмнэл зүй, оношлогооны онцлог сэдвээр АУ-ы докторын зэрэг хамгаалсан.

**Dagvadorj-mail@ yahoo.com**



**Рагчаагийн Бямбаа**

Үхэр жилтэй. АУДС-ийг 1973 онд төгссөн. 1979 онд ЗХУ-д мэргэжил дээшлүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн магистр хамгаалсан. 1986 онд Хөдөөгийн хүн амд үзүүлэх эх барих тусламжийг боловсронгуй болгох асуудлууд сэдвээр анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан. 2004 онд дэд профессор. «Өгөөтэй аваатай хорвоо», «Гуугүй бурхад», «Шүтээн мину», «Манай аравынхан» »Хужирт рашаан сувилал өнө, өнөө, хойч», номууд хэвлүүлсэн. Ор шүтсэн тнгтнлцнн олигтой үр дүнд хүрэхгүй нь ээ» «Тангарагтай хүлээстэй миний муусайн найз нар», «Эрүүл мэндийн эдийн засаг эрүүлжих үү? зэрэг дорвитой нийтлэлүүд бичсэн. Монголын сэтгүүлчдийн эвлэлийн ган үзэгтэн шагналтай.

31/03/2



**Онош сэтгүүлийн цэцийн гишүүн Б.Ганбаатарын эрдмийн зэрэг хамгаалсан бүтээлийн товч бичиглэл**

**Овог: Ширээт Ишжугнай**

**Нэр: Балдан Ганбаатар**

**Эрхэлж буй ажил: ЭМШУИС, Био-Анагаахын сургуулийн бичил амь дархлаа судлалын тэнхмийн профессор**

**Мэргэжил: Мэс заслын их эмч, вирус судлаач, багш**

**Эрдмийн зэрэг хамгаалсан он: 1985**

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв, судалгааны товч агуулга, үр дүн:

«Bedeutung der biologischen stabilität des Masern-Lebend-Impfstoffes im Hinblick und Festlegungen zur Masernbekämpfung in der MVR» Монгол хэлнээ хөрвүүлбэл БНМАУ-ын (хуучин нэршлээр) нөхцөлд Улаанбурхан

өвчинтэй тэмцэх асуудлыг шийдвэрлэхэд Улаанбурханы амьд вакцины тогтворт чанарын ач холбогдол сэдвээр БНАГУ-ын (хуучин нэршлээр) эмч нарын мэргэжил дээшлүүлэх академийн хэрэглээний вирус судлалын хүрээлэнд 1985 оны 10 сарын 15-ны өдөр Берлин хотноо Анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан.

Улаанбурханы вакцин хэрэглэж байгаа улс оронд вакцин тариулсан хүүхэд өвчлөх тохиолдлыг нэгтгэн дүгнэж, вакцины дархлаа тогтоох чадамжийн үндсэн критери үзүүлэлт хэмээн тэмдэглэх болсон температур, rct 40 marker мэдрэмжийг тухайн үед хэрэглэж байсан L-16/SSW болон L-16 омогт судлаж, Улаанбурханы вакциныг тарьж хэрэглэх товлал болон тэр үед баримталж буй аргачлалыг шинэчлэн өөрчлөх, тухайлбал бидний судалгааны үзүүлэлтээр тогтоогдсон 30 минут 21.70C-т PFU/ml Lg103.5-103.1 хувилбарыг практик хэрэглээнд сонгох санал дэвшүүлж, вакцин хэрэглэх аргачлалтай судалгааны үзүүлэлтийг харьцуулан Улаанбурханы амьд вакцин температур, хугацааны хам үйлчлэлийг дахин хянах буюу дархлаа тогтоох чадамжийг, вакцин тарих аргачлалд заасан заалт Lg102,1 хүртэл бууруулах нөхцөл бүрдүүлж байна гэсэн дүгнэлт гаргаснаар улаанбурханы вакцины биологийн идэвхит чанар дархлаа өдөөх чадамж нь вакциныг хадгалах, тээвэрлэх, найруулж хэрэглэх техник ажилбартай холбоотой учраас вакцины аргачлал зааврыг шинэчлэн боловсруулах үндэслэл болсонд оршино. Судалгааны уг ажлыг Монгол оронд үргэлжлүүлэн хийж, Улаанбурханы вакцин эхлэл, тарих нас болон давтан тарих хугацааг, эхээс урагт дамжих дархлаа, халдварын болон вакцины дархлаа тогтоцын үзүүлэлттэй харьцуулан судлаж, Монгол оронд хэрэглэж буй Улаанбурханы вакцины товлалыг шинэчлэн боловсруулсан нь одоо эрүүлийг хамгаалахын практикт хэрэгжиж байна.



**Галсан-Ёндонгийн Сүхбат**

**/Анагаах Ухааны доктор, профессор,**

**Олон улсын шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн/**

Өвөрхангай аймгийн Уянга сумд төрсөн. 1961-1971 онд Өвөрхангай аймагт Ерөнхий боловсролын дунд сургууль, 1971-1977 онд АУДС -ийг тус тус онцсайн дүнтэй, Сүхбаатарын нэрэмжит цалинтай төгсөж, хүний их эмчийн мэргэжил эзэмшсэн. Мөн 1980-1981 онд МУИС-ийн сурганы курсээр багш, 1983-1986 онд ОХУ аспирантурт суралцаж физиологч, 2000-2001 онд Олон улсын гадаад хэлний төвд суралцаж англи хэлний орчуулагч мэргэжил тус тус эзэмшсэн.

1986 онд ЗХУ -н П.К.Анохины нэрэмжит Эрүүл физиологийн эрдэм шинжилгээний хүрээлэнд академич, доктор, профессор К.В.Судаковын удирдлагаар « Тааламжгүй сэтгэл хөдлөлийн төвийн механизмд дельта нойр үүсгэдэг пептидын оролцоо» сэдвээр анагаах ухааны докторын /Ph.D/зэрэг хамгаалсан. 1992 онд дэд профессор, 2002 онд профессор, 2002 онд Олон улсын шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн/академич/ цол тус тус хүртсэн.

1977-оноос өнөөг хүртэл АУДС, АУИС, ЭМШУИС –д багш, тэнхимийн эрхлэгч, 2008 оноос тус сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар, 2004 оноос «Аварга» БТДС–ийн тэргүүн дэд захиралаар үр бүтээлтэй ажиллаж байна.

Г. Сүхбат улсад 30 гаруй жил ажиллахдаа 350 гаруй бүтээл туурвиж 25 хүний эрдмийн ажлыг удирдаж доктор, магистрын зэрэг хамгаалуулж, 10 гаруй их дээд сургуулиудын 10 гаруй мянган оюутан залуучуудад, олон зуун эмч, багш, дасгалжуулагч нарт хичээл зааж, гадаад, дотоодын - 5 төсөлт ажлыг удирдан хугацаанд чанартай хүлээлгэн өгч, 3 төсөлт ажилд хамтран гүйцэтгэгчээр оролцож оюуны томоохон хөрөнгө оруулалт хийсэн болно.

Гурван их дээд сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүн, Монголын үндэсний олимпын академийн дэд ерөнхийлөгч, ЭМЯ-ны физиологийн ерөнхий мэргэжилтэн, Олон улсын шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн, Азийн спортын менежментийн холбооны дэд ерөнхийгч, МҮОХ –ны гишүүн Онош, Биеийн тамирын онол арга зүй, Азийн спортын менежмент сэтгүүлүүдийн редакцийн зөвлөлийн гишүүн болой

н.Сүхбат 1981 онд Биеийн тамирын тэргүүний ажилтан, 1993 онд Боловсролын тэргүүний ажилтан, 1998 онд Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан цол тэмдэгээр, 2001 онд Ардын хувьсгалын 80 жилийн ойн медалиар, 2003 онд Хөдөлмөрийн хүндэт медаль , ЭМШУИС ийн хүндэт өргөмжлөлөөр, 2005 онд Монголын Их Дээд Сургуулийн холбооны «Шилдэг багш» 2007 онд «Хүндэт захирал» өргөмжлөлөөр 2006, 2008 онуудад, МҮОХ –ны 50 жилийн ойн медаль (2006), Дэлхийн алдарт физиологч П.К. Анохины нэрэмжит алтан медаль (2007), Спортын алдар медалиар(2007) Шинжлэх ухааны тэргүүний ажилтан цол тэмдэгээр(2008) МҮОХ –ны дээд шагнал Алтан-Очир одонгоор (2009) тус тус шагнагджээ.

E-mail : [su51bat@yahoo.com](mailto:su51bat@yahoo.com) and [sukhbat@hsum.edu.mn](mailto:sukhbat@hsum.edu.mn)



### **Гэндэнгийн Зулхүү**

**Төрсөн он: 1950 сар 11 өдөр 25**

**Төрсөн нутаг: -Өмнөговь аймаг Сэврэй сум**

Өмнөговь аймгийн Сэврэй, Баяндалай суманд дунд сургууль дүүргэж, Дорноговь аймгийн Анагаах Ухааны Дунд Сургуульд (1965-1969) суралцаж эх баригч бага эмч, Улаанбаатар хот Анагаах Ухааны Дээд Сургуулийн (1973-1979) эмчилгээний ангийг дүүргэж хүний их эмч мэргэжил эзэмшсэн. БНАГУ-д клиник ординатурт (1983-1985) дүүргэсэн.

Өмнө-говь аймгийн Гурвантэс суманд бага эмч 1969-1973 онд, Говь алтай аймагт Хүүхэд-халдвартын эмч, тасгийн эрхлэгч (1979-1989), ЭМШУИС –ийн халдвартын тэнхимд багш 1989 оноос эдүгээ

хүртэл ажиллаж байна.

Халдвартын эмчийн тэргүүлэх зэргийг 1988, 1993 онуудад хамгаалсан, Анагаах Ухааны Доктор (Ph.D) зэргийг 1998 онд «Хүүхдийн Дельта гепатитын эмнэлзүй, төгсгөл, эмчилгээ» сэдвээр хамгаалсан. ЭМШУИС-ийн дэд профессор цол 2006 онд хүртсэн. Эрдэм шинжилгээний 50 гаруй бүтээл туурвиж дотоодын болон ОХУ, БНХАУ, ХБНГУ, Швейцарь зэрэг гадаад орны хуралд хэлэлцүүлсэн.

Эрүүл Мэндийн Яамны халдварт өвчин-тархварзүйн мэргэжлийн зөвлөлийн гишүүн, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн зөвлөх эмчээр ажилладаг.



**Намдагийн Бира**  
**bira602000@yahoo.com**

1997 онд Монгол улсын Анагаах Ухааны Их Сургуульд Доторын өвчин судлалын чиглэлээр Анагаах ухааны магистрын боловсрол

2001 онд ОХУ-ын Казань хотын Каканий Анагаахын Академи-д «Улаанбаатар хотын насанд хүрэгчдийн дунд тохиолдох Helicobacter pylori хамааралт болон хамааралт бус архаг гастритийн эмнэл зүй-эмгэг бүтцийн онцлог»

ЭМШУИС-АУС-Хоол боловсруулах эрхтэн судлалын тэнхимийн эрхлэгч, дэд профессор

Ходоодны дурангийн эмч, мэргэжилтний нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, Монголын гастроэнтерологи эмч нарын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн



**Хасаг Оюунцэцэг**  
**99810180**  
**k-oyuntsetseg@yahoo.com**  
**1982 АУДэС хүний их эмч**

Ходоод ,дээд гэдэсний шархлаа өвчний дурангийн оношлогоо эмчилгээг боловсронгуй болгох асуудалд сэдвээр докторын зэрэг хамгаалсан.

ЭМШУИС ,ХБЭСТэнхим ахлах багш

Ходоод гэдэсний дурангийн эмч мэргэжилтнүүдийн нийгэмлэгийн тэргүүн



**Цэрэнчимэдийн САРАНТУЯА**  
**c\_sarantuya@yahoo.com**

Ходоод-улаан хоолойн сөөргөө өвчний үеийн ходоод, улаан хоолойн бүтэц, үйл ажиллагааны онцлог сэдвээр докторын зэрэг хамгаалсан.

ЭМШУИС, АУС, Хоол боловсруулах эрхтэн судлалын тэнхимд ахлах багш

Монголын гастроэнтеролог эмч нарын нийгэмлэг, нарийн бичгийн дарга.

Ходоод, гэдэсний дурангийн эмч, мэргэжилтний нийгэмлэг, нарийн бичгийн дарга



МОНГОЛЫН ГАСТРОЭНТЕРОЛОГИ ЭМЧ НАРЫН  
НИЙГЭМЛЭГИЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

# ОНОШ

1999/1

Улаанбаатар хот

Эхний дугаар 1999 оны 1 сарын 12



МОНГОЛЫН АНАГААХ УХААНЫ МЭРГЭЖЛИЙН  
НИЙГЭМЛЭГҮҮДИЙН СЭТГҮҮЛ



# ОНОШ

№4(44)

2009



Улаанбаатар хот

10н жилийн ойн дугаар 2009 оны 11 сарын 22